



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

selenge.gov.mn/beta/shilen_dans/2

СЭЛЭНГЭ АЙМАГ
АЛБАН ЕСНЫ ЦАХИМ ХУУДАС

Аймгийн тухай | Удирдлага | Талс зөвлөл | Мэдрээ | Нийгэм, эрх | Ил тод байдал | Шилэн данс | Агентагууд

ШИЛЭН ДАНС

Аймгийн Засаг дарга /нөөц/ | Орон нутгийн хөгжлийн сан | Орон нутгийн хөрөнгө оруулалт | Авто замын сан | АЗДТГ

№	Худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр	Батлагдсан төсвөг өртөг	Гэрээний дүн	Савхууцлийн хэмжээ	Нийлүүлэгчийн нэр, хаяг	Огноо
1	Алтанбулаг, СБ сумдад нийтийн бие засах газар барих	55,000,000₮	55,000,000₮	29,971.512₮	Сүлдханба ХХК, Талхун Арал ХХК	2016-12-22
2	Цагааннуур суманд 1.2 км хатуу хучилттай зам тавих	651,910,100₮	100,000,000₮	100,000,000₮	Сэлэнгэ Есөн эрдэнэ ХХК	2016-12-22
3	Ерөө суманд хөлбөмбөгийн талбай барих	140,000,000₮	114,083,496₮	114,083,496₮	Талхун арал ХХК, ТЭТҮ ХХК	2016-12-16
4	СБ сумын Хонгорморьт 1-р багт тоглоомын талбай байгуулах	25,000,000₮	24,999,878₮	24,999,878₮	Талхун арал ХХК, Хүнчит Сэлэнгэ ХХК	2016-12-15
5	Мандал суманд бэлчээрийн гүний худаг гаргах	20,000,000₮	19,720,480₮	19,720,480₮	Талхун арал ХХК, Дашдонг ХХК	2016-12-14
6	Баян-Ольгоны багцны сумд хиллэг гэрээх	20,000,000₮	19,720,480₮	19,720,480₮	Талхун арал ХХК, Дашдонг ХХК	2016-12-14

Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллага, аж ахуйн нэгжүүд шилэн дансны цахим санд мэдээлбэл зохих 102,772.0 сая төгрөгийн мэдээллээс 93,879.6 сая төгрөгийн буюу 91.3 хувийг мэдээлсэн байна.

Агуулга

**Тайланг
бэлтгэсэн:**

Сэлэнгэ аймаг
дахь Төрийн
Аудитын газар

Дарга, тэргүүлэх
аудитор
Ч.Энхтуяа

Аудитын менежер
Б.Батмөнх

Ахлах аудитор
Б.Наранчимэг
С.Бат-Эрдэнэ
С.Баасансүрэн

Аудитор
Ц.Отгонбаяр
Ц.Уртнасан
Э.Эрдэнэзул
А.Дашбат
Ж.Цогт

**2017 оны 10-11
сар**

Аудитын тайлан,
дүгнэлттэй
холбоотой
асуудлаар нэмж
тодруулах, асууж
лавлах зүйл
байвал 70362442,
70363036
дугаарын утас,
70363040
дугаарын факсаар
харилцана уу.

ХАЯГ:

Сэлэнгэ аймгийн
Сүхбаатар сум
аймгийн ЗДТГ-ын
байрны өргөтгөлд

Товчилсон үгийн жагсаалт.....
Аудит хийх үндэслэл.....
Аудитын зорилт.....
Аудитын хамрах хүрээ.....
Арга зүй.....
Шалгуур үзүүлэлт, хугацаа.....
Ерөнхий мэдээлэл.....
Аудитын дүн:.....
БҮЛЭГ.А Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд нь шилэн дансны цахим хуудсаар мэдээлбэл зохих 12907 удаагийн мэдээллээс 10674 буюу 82.6 хувийг, самбараар мэдээлбэл зохих 12907 удаагийн мэдээллээс 9057 буюу 70.1 хувийг мэдээлсэн байна.

А.1. Шилэн дансны тухай хуулийн үйлчлэлд хамаарах 386 хуулийн этгээд цахим санд өөрийн нэрээр цэс үүсгэсэн байна.

А.2. Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд нь шилэн дансны цахим хуудсаар мэдээлбэл зохих 12907 удаагийн мэдээллээс 10674 буюу 82.6 хувийг, самбараар мэдээлбэл зохих 12907 удаагийн мэдээллээс 9057 буюу 70.1 хувийг мэдээлсэн байна.

БҮЛЭГ.Б Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд нь шилэн дансны цахим хуудсанд нийт мэдээлбэл зохих 102,772.0 сая төгрөгийн мэдээллээс 93,879.6 сая төгрөгийн буюу 91.3 хувийг мэдээлсэн байна.

Б.1. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газрууд Шилэн дансны тухай хуулийн 6-р зүйлийн 6.1-д заасан мэдээлбэл зохих 5171 мэдээллээс 4491 буюу 86.8 хувийг мэдээлсэн байна.

Б.2. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газрууд 7 хоногийн дотор мэдээлбэл зохих 7734 мэдээллээс 6184 буюу 80.0 хувийг мэдээлсэн байна.

Б.4. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т хамаарах “Сэлэнгэ АЗЗА” ТӨХК нь 6 дугаар зүйлийн 6.8-д заасан мэдээлбэл зохих мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

Б.5. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа ААНБ болон төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байгууллагууд Шилэн дансын тухай хуулийн 6-р зүйлийн 6.9-д заасан мэдээлбэл зохих 405 мэдээллээс 375 буюу 92.6 хувийг мэдээлсэн байна.

БҮЛЭГ.В Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд багийн ИНХ –ын зүгээс нэг ч хяналт хийгдээгүй байна.

В.1 Багийн иргэдийн Нийтийн хурал нь холбогдох байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

В.2 Аймгийн ТЕЗ-ийн дотоод аудитын албанаас 2017 онд шилэн дансны үйл ажиллагаанд 2 удаа хяналт, шалгалт хийсэн байна.

В.3 Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн өмчит хувьцаат компани зэрэг нийт 251 хуулийн этгээдээс 21 буюу 8 хувь нь дээд шатны байгууллагатай байгуулсан үр дүнгийн гэрээнд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг тусгаагүй байна.

В.4 Шилэн дансны тухай хуулийн талаар иргэд, олон нийт тодорхой ойлголттой болсон боловч мэдээллийн цахим сангийн хандалтын талаар мэдээлэл авах боломжгүй байна.

БҮЛЭГ.Г Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг бүрэн биелүүлсэн бол зөвлөмжийг 79,2 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Г.1 Өмнөх аудитаар өгөгдсөн албан шаардлагыг бүрэн биелүүлсэн байна.

Г.2 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг дунджаар 79.2 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Илрүүлсэн зөрчил.....

Дүгнэлт.....

Зөвлөмж.....

Холбогдох байгууллагын санал.....

Хавсралтууд.....

Товчилсон үгийн жагсаалт

УИХ	Улсын Их Хурал
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХО	Хөрөнгө оруулалт
ЗД	Засаг дарга
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ХМХА	Хилийн мэргэжлийн хяналтын алба
ЭМНДХ	Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс
ХГБХХ	Хүүхэд, гэр бүл хөгжлийн хэлтэс
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ОНЕД	Орон нутгийн ерөнхий данс
ИНХ	иргэдийн Нийтийн Хурал
ИТХ	иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ТЭДС	Тариалан эрхлэлтийг дэмжих сан
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ТҮГ	Тохижилт үйлчилгээний газар
АЗЗА	Авто зам, засвар арчлалт
ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1. Аудит хийсэн үндэслэл

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2017 оны 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт 2017 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд нийцлийн аудит хийж гүйцэтгэв.

2. Аудитын зорилт, хамарсан хүрээ

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалган дүгнэлт, зөвлөмж өгч, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулах, олон нийтэд мэдээлэхэд нийцлийн аудитын зорилт оршив. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

1. Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд бүрэн хамрагдаж, мэдээлэл хүргэх хэлбэрийг баримталсан эсэх,
2. Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд шилэн дансны мэдээллийг бүрэн мэдээлж байгаа эсэх,
3. Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлсэн эсэх,
4. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэх.

Аудитад 2016 оны 4-р улирал, 2017 оны 3-р улирлын байдлаар Сэлэнгэ аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй, Шилэн дансны тухай хуулийн үйлчлэлд хамаарах улсын төсвийн 47, орон нутгийн төсвийн 173, аймаг, сумдын ТЭЗ 18, орон нутгийн өмчит аж ахуйн нэгж 12, төрийн өмчит компани 1, улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн аж ахуйн нэгж 113, төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээ үзүүлж буй байгууллага 22 зэрэг нийт 386 хуулийн этгээдийг хамруулав.

3. Аудитын арга зүй:

Аудитаар АДБОУС 100-400, 4000, 4100 дугаар стандартууд болон Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журмыг баримтлан Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторов баталсан дэд төлөвлөгөөний дагуу хуулийг хэрэгжүүлэгч байгууллагуудын мэдээллийн самбар болон цахим хуудаст байрлуулсан мэдээллийг дансны хуулгын дүн, анхан шатны баримт, журналтай тулгах, дүн шинжилгээ хийх, аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, мэргэжилтнүүд, Санхүүгийн хяналт, аудитын албаны ажилтнууд, төсөвт байгууллагын дарга, нягтлан бодогчид болон холбогдох ажилтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, судлах, харьцуулалт хийх, тулган баталгаажуулах, нөхцөл байдлын шинжилгээ хийх зэргээр нотлох зүйл цуглуулан аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

4. Аудитын шалгуур үзүүлэлт, хугацаа

“Төсвийн тухай хууль”, “Төрийн аудитын тухай хууль”, “Шилэн дансны тухай хууль”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”, “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”, “ТБОНӨХБАҮХА тухай хууль”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”, Засгийн газрын 2016 оны 01-р сарын 11-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах

мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам” болон бусад холбогдох хууль тогтоомж, эрхийн актуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, ахлах аудитор Б.Наранчимэг, С.Бат-Эрдэнэ, С.Баасансүрэн, аудитор Ц.Отгонбаяр, Ц.Уртнасан, Э.Эрдэнэзул, А.Дашбат, Ж.Цогт нар 2017 оны 10 дугаар сарын 17-ны өдрөөс 11 дүгээр сарын 20-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэв.

5. Ерөнхий мэдээлэл

Сэлэнгэ аймгийн хэмжээнд Шилэн дансны тухай хуулийн үйлчлэлд хамаарах төрийн болон орон нутгийн өмчит байгууллага 232, аймаг, сумдын ТЭЗ 18, ТӨХК 1, улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа 113 аж ахуйн нэгж, төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг үзүүлдэг 22 байгууллага зэрэг нийт 386 хуулийн этгээд үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд эдгээр бүх байгууллага, аж ахуйн нэгжүүд шилэн дансны цахим санд өөрийн нэрээр цэс үүсгэсэн байна.

Цэс үүсгэсэн хуулийн этгээдүүдийн мэдээлэл байршуулалтыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1

Хууль, журмын заалт	Байгууллагын төрөл	2016 оны 3-р улирал		2017 оны 3-р улирал	
		Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагын тоо	Мэдээлэл байршуулсан байгууллагын тоо	Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагын тоо	Мэдээлэл байршуулсан байгууллагын тоо
3.1.1 дэх заалт	Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд	231	230	232	229
3.1.2 дахь заалт	Төрийн өмчит үйлдвэрийн газар	-	-	-	-
3.1.3 дахь заалт	Хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани	1	1	1	1
ЗГ-ын 29-р тогтоолоор батлагдсан журмын дагуу	Төсвийн ерөнхийлөн захирагч	18	18	18	18
3.1.4 дэх заалт	Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага	92	0	113	113
3.1.5 дахь заалт	Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч	44	9	22	12
Нийт дүн		386	258	386	373

Дээрх хүснэгтээс харахад хуулийн үйлчлэлд хамаарч, өмнөх онд аудитад

хамрагдсан байгууллагуудаас 24 байгууллага хасагдаж, 24 байгууллага нэмэгдсэн байна. Үүнд:

Хасагдсан байгууллагууд:

- Засгийн газрын 2016 оны 08-р сарын 03-ны өдрийн 9 дүгээр тогтоолоор Хөдөлмөрийн хэлтэс, Халамж үйлчилгээний хэлтсийг нийлүүлж Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Орон нутгийн өмчийн алба, Худалдан авах ажиллагааны албыг нийлүүлж Орон нутгийн өмчийн газар гэсэн нэртэй болгосон байна.
- 10,0 сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч 22 байгууллага.

Дараах байгууллагуудыг аудитад нэмж хамрууллаа. Үүнд:

- Өмнөх аудитад хамрагдаагүй Мандал сумын Мандал Хишиг хайрхан, Ерөө сумын Төгөлдөр Ерөө ОНӨААТҮГ-ууд,
- 10,0 сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа 21 аж ахуйн нэгж, байгууллага
- Мандал суманд шинээр байгуулагдан, 2017 оны 09-р сарын 01-ний өдрөөс үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн ерөнхий боловсролын бүрэн дунд 4 дүгээр сургуулийг тус тус нэмж хамрууллаа.

АУДИТЫН ДҮН

Бүлэг А

Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд бүрэн хамрагдаж, мэдээлэл хүргэх хэлбэрийг баримталсан эсэх

Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд нь шилэн дансны цахим хуудсаар мэдээлбэл зохих 12905 удаагийн мэдээллээс 10675 буюу 82.7 хувийг, самбараар мэдээлбэл зохих 12905 удаагийн мэдээллээс 9057 буюу 70.1 хувийг мэдээлсэн байна.

А.1. Шилэн дансны тухай хуулийн үйлчлэлд хамаарах 386 хуулийн этгээд цахим санд өөрийн нэрээр цэс үүсгэсэн байна.

Сэлэнгэ аймгийн хэмжээнд 2017 оны 3 дугаар улирлын байдлаар Шилэн дансны тухай хуулийн үйлчлэх хүрээний 3.1.1-д хамаарах улсын төсөвт 47, орон нутгийн төсөвт 173, орон нутгийн өмчит 12 зэрэг нийт 232, 3.1.3-т хамаарах 1, 3.1.4-т хамаарах 113, 3.1.5-д хамаарах 22 зэрэг нийт 386 хуулийн этгээд үйл ажиллагаа явуулж байна.

Дээрх 386 хуулийн этгээд шилэн дансны цахим санд өөрийн нэрээр цэс үүсгэсэн боловч “Төгөлдөр-Ерөө”, “Мандал хишиг хайрхан” ОНӨААТҮГ-ууд 2017 оны эхний 3 улирлын байдлаар мэдээлбэл зохих мэдээллийг огт байршуулаагүй байна.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэл байршуулсан 22 хэлтэс, агентлаг болон ОНХС, орон нутгийн ХО, замын сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн

төсөл, арга хэмжээ, Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтын мэдээллийг *Selenge.gov.mn* гэсэн аймгийн цахим хуудсаас дэлгэрэнгүй харж болохоор холболт хийгдэн, мэдээллийг давхар түгээж байна.

Баянгол, Мандал, Орхонтуул сумдын Улсын нөөцийн салбарыг 2017 оны 04-р сарын 01-ний өдрөөс татан буулгаж, Онцгой байдлын салбаруудад нэгтгэсэн тул тусдаа мэдээлэл оруулах шаардлагагүй болсон байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т заасан хуулийн этгээдээс Сэлэнгэ аймагт “Сэлэнгэ АЗЗА” ТӨХК үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд уг компани нь шилэн дансны цахим цэсэнд өөрийн нэр, хаягаар бүртгэлтэй байна.

Аймгийн хэмжээнд 2017 оны 3 дугаар улирлын байдлаар улс, орон нутгийн төсөв, ОНХС, замын сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч 113 аж ахуйн нэгжид 4,408.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон бөгөөд аж ахуйн нэгжүүдийн талаарх мэдээллийг төр, төсвийн байгууллагууд өөрсдийн шилэн дансны цахим хуудсаар мэдээлсэн байна.

/ Дэлгэрэнгүйг Судалгаа 4-т харуулав /

Сэлэнгэ аймагт 10,0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэж буй аймгийн Ахмадын хороо, Албан журмын даатгуулагчдын холбоо тус бүр 1, хувийн сургууль 2, цэцэрлэг 3, өрхийн эмнэлэг 7, мал эмнэлэг 8 зэрэг нийт 22 байгууллага шилэн дансны цахим цэсэнд өөрийн нэр, хаягаар бүртгэлтэй байна.

А.2. Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд нь шилэн дансны цахим хуудсаар мэдээлбэл зохих 12905 удаагийн мэдээллээс 10675 буюу 82.7 хувийг, самбараар мэдээлбэл зохих 12905 удаагийн мэдээллээс 9057 буюу 70.1 хувийг мэдээлсэн байна.


Тайлант оны 3 дугаар улирлын байдлаар аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон орон нутгийн өмчит 250 хуулийн этгээд нь шилэн дансны цахим хуудсаар мэдээлбэл зохих 25810 удаагийн мэдээллээс 19732 удаагийн буюу 76.4 хувийг мэдээлсэн байна. Үүнийг дараах хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 2

Үзүүлэлт	Байгууллагын тоо	Цахим хуудаст мэдээлсэн тоо		Самбараар мэдээлсэн тоо		Нийт		Мэдээлсэн дүн /%I
		Мэдээлбэл зохих	мэдээлсэн	Мэдээлбэл зохих	мэдээлсэн	Мэдээлбэл зохих	мэдээлсэн	Хувиар
Улсын төсөвт байгууллага	47	3161	2874	3161	2244	6322	5118	80.9
Аймгийн ТЭЗ-ийн харьяа байгууллага	191	8688	6984	8688	6083	17376	13067	75.2
ОНӨААТҮГ	12	1056	817	1056	730	2112	1547	73.2
Дүн	250	12905	10675	12905	9057	25810	19732	76.4


Дээрх судалгаанаас үзэхэд мэдээлбэл зохих мэдээллийг улсын төсвийн 47 хуулийн этгээд 80.9 хувийг, орон нутгийн төсвийн 191 хуулийн этгээд 75.2 хувийг, орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд 73.2 хувийг тус тус мэдээлсэн байна.

Зураг 1



Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т заасан хуулийн этгээдээс Сэлэнгэ аймагт “Сэлэнгэ АЗЗА” ТӨХК үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн холбогдох мэдээллийг цахимаар болон самбараар мэдээлсэн байна.

Зураг 2



Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 болон 3.1.5-д хамаарах улс, орон нутгийн төсөв, ОНХС, замын сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдийн мэдээллийг санхүүжүүлэгч төр, төсвийн байгууллагууд өөрсдийн шилэн дансны цахим хуудас болон мэдээллийн самбараар бүрэн мэдээлсэн байна.

Бүлэг Б

Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд шилэн дансны мэдээллийг бүрэн мэдээлж байгаа эсэх

Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд нь шилэн дансны цахим хуудсанд нийт мэдээлбэл зохих 102,772.0 сая төгрөгийн мэдээллээс 93,879.6 сая төгрөгийн буюу 91.3 хувийг мэдээлсэн байна.

Оршил :

2017 оны 3 дугаар улирлын байдлаар Сэлэнгэ аймагт үйл ажиллагаа явуулж буй Шилэн дансны тухай хуулийн үйлчлэлд хамаарах 386 хуулийн этгээд нь нийт 13314 удаагийн 102,772.0 сая төгрөгийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим санд мэдээлэхээс 11054 удаагийн 93,879.6 сая төгрөгийн мэдээллийг байршуулсан нь мэдээлбэл зохих мэдээллийн тооны хувьд 83,0 хувийн, мөнгөн дүнгийн хувьд 91,3 хувийн хэрэгжилттэй байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 3

Д/д	Байгууллагын нэр	Мэдээллийн тоо			Мөнгөн дүн /сая.төгрөг/		
		Мэдээлбэл зохих	Мэдээлсэн	Хувь	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн	Хувь
1	Улсын төсөвт	3161	2874	90.9	47,780.2	46,516.7	97.4
2	ТӨХК /Сэлэнгэ АЗЗА /	4	4	100	777.8	777.8	100
3	ТЕЗ-ийн харьяа байгууллагууд	10149	8176	80.5	54,214.0	46,585.1	85.9
	ДҮН	13314	11054	83.0	102,772.0	93,879.6	91.3

Хүснэгтээс харахад улсын төсөвт байгууллагууд нийт мэдээлбэл зохих 47,780.2 сая төгрөгийн мэдээллийн 97,4 хувийг, орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагууд мэдээлбэл зохих 54,214.0 сая төгрөгийн мэдээллийн 85,9 хувийг тус тус шилэн дансны цахим санд байршуулсан байна.

Б.1. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газрууд Шилэн дансны тухай хуулийн 6-р зүйлийн 6.1-д заасан мэдээлбэл зохих 5171 мэдээллээс 4491 буюу 86.8 хувийг мэдээлсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь хуулийн 6.1-6.3-т заасан 17-21 төрлийн мэдээллийг тогтмол хугацаанд нийтэд ил тод мэдээлэхээр хуульчлагдсан байдаг.

Тайлант оны 3-р улирлын байдлаар аймгийн хэмжээнд улсын төсвийн 47, орон нутгийн төсвийн 173 байгууллага, ТЕЗ- 18, орон нутгийн өмчит аж ахуйн нэгж 12 зэрэг нийт 250 хуулийн этгээд давхардсан тоогоор 5171 удаагийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэхээс 4490 удаагийн буюу 86.8 хувийн мэдээллийг мэдээлсэн байна. Үүнийг дараах хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 4

Хуулийн заалт	Хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд тогтмол хугацаанд мэдээлэл байршуулсан байдал	Мэдээлбэл зохих мэдээллийн тоо					Үүнээс цахимаар болон самбараар мэдээлсэн тоо					
		Улсын төсөвт	Орон нутгийн төсөвт	ТЕЗахирагч	ОНӨААТҮГ	Дүн	Улсын төсөвт	Орон нутгийн төсөвт	ТЕЗахирагч	ОНӨААТҮГ	Дүн	Хувиар %
	Байгууллагын тоо	47	173	18	12	250	47	173	18	9	247	98.8
	Мэдээллийн тоо. Үүнээс:	946	3589	396	240	5171	799	3186	360	146	4491	86.8
6.1.1	Тухайн жилийн төсөв	47	173	18	12	250	43	153	17	8	221	88.4
	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө	47	173	18	12	250	5	29	13	1	48	19.2
	ОНХС-ийн төлөвлөгөө	0	0	18	0	18	0	0	18	0	18	100.0
	Сар улирлын төсвийн гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор	564	2076	216	144	3000	511	2067	199	107	2884	96.1

6.1.3	Дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор	47	173	18	12	250	33	129	13	1	176	70.4
6.1.4	Жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04-р сарын 25-ны өдрийн дотор,	47	173	18	12	250	42	146	15	5	208	83.2
	хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор	47	173	18	12	250	37	149	14	8	208	83.2
6.1.5	ТЕЗ-ын төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор	47	173	18	12	250	43	137	12	5	197	78.8
	Аудитын тайлан дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор	47	173	18	12	250	37	115	13	3	168	67.2
6.1.6	Төсвийн хэтрэлт хэмнэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр	47	173	18	12	250	43	154	14	7	218	87.2
	Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл	0	0	18	0	18	0	0	16	0	16	88.8
	Тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалт	0	0	18	0	18	2	0	16	0	16	88.8
	Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалт	6	129	0	0	135	3	107	0	1	107	79.2

Дээрх судалгаанаас үзэхэд ОНХС-гийн төлөвлөгөөний мэдээллийг 100,0 хувь мэдээлсэн бол дараах 4 төрлийн мэдээллийг бага буюу 19.2-78.8 хувьтай мэдээлсэн байна. /Дэлгэрэнгүйг Судалгаа №1-д харуулав./

Үүнд:

- Хуулийн 6.1.1-д заасны дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны өдрийн дотор мэдээлэхээс 48 нь мэдээлж, 202 нь мэдээлээгүй,
- Хуулийн 6.1.3-т заасны дагуу дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 9 дүгээр сарын 15-ны өдрийн дотор мэдээлэхээс 176 нь мэдээлж, 74 нь мэдээлээгүй,
- Хуулийн 6.1.5-д заасны дагуу ТЕЗ-ийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор мэдээлэхээс 197 нь мэдээлж, 53 нь мэдээлээгүй,
- Хуулийн 6.1.5-д заасны дагуу аудитын тайлан дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг тухайн жилийн 7 дугаар сарын 1-ний өдрийн дотор мэдээлэхээс 168 нь мэдээлж, 82 нь мэдээлээгүй байна.

Харин дараах 7 төрлийн мэдээллийг 83.2-96.1 хувьтай мэдээлжээ. Үүнд:

- Хуулийн 6.1.1-д заасны дагуу тухайн жилийн төсвийг жил бүрийн 01-р сарын 10-ны дотор мэдээлэхээс 221 нь мэдээлж, Хушаат сумын ТЕЗ, ХМХА, аймгийн ЭМНДХ, Сэлэнгэ үржлийн цөм сүрэг, Төгөлдөр-Ерөө, Мандал хишиг хайрхан, Хүдэр ойн анги ОНӨААТҮГ зэрэг 29 хуулийн этгээд мэдээлээгүй,
- Хуулийн 6.1.2-т заасны дагуу сар, улирлын төсвийн гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор 3000 удаа мэдээлэхээс 2884 удаа мэдээлж, 9 байгууллага 1-9 сарын мэдээллийг дутуу оруулсан,
- Хуулийн 6.1.4-т заасны дагуу хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор мэдээлэхээс 208 нь мэдээлж, 42 нь мэдээлээгүй,
- Мөн заалтын дагуу жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04-р сарын 25-ны өдрийн дотор мэдээлэхээс 208 нь мэдээлж, 42 нь мэдээлээгүй,
- Хуулийн 6.1.6-д заасны дагуу төсвийн хэтрэлт хэмнэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр мэдээлэхээс 218 нь мэдээлж, 32 нь мэдээлээгүй,

- Хуулийн 6.1.6-д заасны дагуу тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтыг 18 ТЕЗ мэдээлэхээс 16 нь мэдээлсэн бөгөөд Алтанбулаг, Хүдэр сумдын ТЕЗ мэдээлээгүй,
- Мөн заалтын дагуу орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг 18 ТЕЗ мэдээлэхээс 16 нь мэдээлсэн бөгөөд Алтанбулаг, Хушаат сумдын ТЕЗ мэдээлээгүй байна.

Б.2. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газрууд 7 хоногийн дотор мэдээлбэл зохих 7734 мэдээллээс 6184 буюу 80.0 хувийг мэдээлсэн байна.

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газрууд нь Шилэн дансны тухай хуулийн 6.4-т заасан 4-12 төрлийн мэдээллийг 7 хоногийн дотор нийтэд ил тод мэдээлэхээр хуульчилсан байдаг.

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 250 хуулийн этгээд нь 7 хоногийн дотор 4-12 төрлийн 7734 удаагийн мэдээллийг нийтэд ил тод мэдээлэхээс 6184 удаагийн буюу 80.0 хувийг цахим хуудсаар болон самбараар мэдээлсэн байна. Үүнийг дараах хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 5

Хуулийн заалт	3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд 3-р улирлын байдлаар 7 хоногийн дотор нийтэд ил тод болгох мэдээлэл	Мэдээлбэл зохих мэдээллийн тоо					Үүнээс цахимаар болон самбараар мэдээлсэн тоо					
		Улсын төсөвт	Орон нутгийн төсөвт	ТЕЗахирагч	ОНӨААТҮГ	Дүн	Улсын төсөвт	Орон нутгийн төсөвт	ТЕЗахирагч	ОНӨААТҮГ	Дүн	Хувиар %/
3.1.1, 3.1.2	Байгууллагын тоо	47	173	18	12	250	47	173	18	9	247	98.8
	Мэдээллийн тоо. Үүнээс:	2215	4037	668	814	7734	2075	2825	613	671	6184	80.0
6.4.1	Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт	47	173	18	12	250	44	163	17	6	230	92.0
6.4.2	Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт	19	56	0	12	87	19	56	0	4	79	90.8
6.4.3	Тендер, худалдан авалттай холбоотой мэдээлэл	55	178	226	26	485	49	104	204	8	365	75.2
6.4.4	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг	346	985	199	48	1578	292	527	192	37	1048	66.4
6.4.5	Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ	1293	810	99	301	2503	1272	582	89	290	2233	89.2
	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ	206	98	72	260	636	203	46	69	257	575	90.4
6.4.6	Худалдан авалтын аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн	47	173	18	12	250	40	172	17	5	234	93.6
6.4.7	Байгууллагуудын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт	42	173	0	12	227	38	162	0	8	208	91.1
6.4.8	Төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл	113	1218	18	116	1465	62	812	7	43	924	63.0

	Өр үүсгэсэн шийдвэрийн талаарх мэдээлэл	0	0	0	3	3	0	0	0	3	3	100.0
6.4.9	Хууль тогтоомжинд заасан бусад мэдээлэл	47	173	18	12	250	47	173	18	9	247	98.8

Дээрх судалгаанаас үзэхэд 11 төрлийн мэдээллээс дараах 3 төрлийн мэдээллийг хамгийн бага буюу 63.0-75.2 хувьтай мэдээлсэн байна. Үүнд:

- Хуулийн 6.4.3-т заасны дагуу тендер, худалдан авалттай холбоотой 485 тендерт оролцогчийн талаар мэдээлэхээс 365 оролцогчийн талаар мэдээлж, 120 оролцогчийг мэдээлээгүй,
- Хуулийн 6.4.4-т заасны дагуу 5,0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийн мэдээлэл болох 1578 удаагийн 27,326.6 сая төгрөгийн гүйлгээг мэдээлэхээс 1048 удаагийн 23,447.3 сая төгрөгийн гүйлгээг мэдээлж, аймгийн ХГБХХ нь 11 удаагийн 210.8 сая төгрөгийн, Шаамар сумын МСҮТ нь 3 удаагийн 229.7 сая төгрөгийн, Сайхан сумын 12 жилийн сургууль нь 49 удаагийн 316.6 сая төгрөгийн зэрэг нийт 530 удаагийн 3,879.3 сая төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй,
- Хуулийн 6.4.8-д заасны дагуу төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээллийг 1465 удаагийн 4,833.5 сая төгрөгийн шийдвэрийг мэдээлэхээс 961 удаагийн 3,841.1 сая төгрөгийн шийдвэрийг мэдээлж, Сэлэнгэ-Энерго ОНӨААТҮГ нь 36 удаагийн 76.2 сая төгрөгийн, Шаамар МСҮТ нь 3 удаагийн 45.9 сая төгрөгийн, Ерөө сумын ТЕЗ нь 1 удаагийн 40.0 сая төгрөгийн зэрэг нийт 467 удаагийн 992.4 сая төгрөгийн шийдвэрийг мэдээлээгүй байна.

Харин дараах 3 төрлийн мэдээллийг хамгийн өндөр хувьтай буюу 93.6-100.0 хувьтай мэдээлжээ. Үүнд:

- Хуулийн 6.4.6-д заасны дагуу бусад хяналт шалгалтын дүнг 234 нь мэдээлж, 16 нь мэдээлээгүй,
- Хуулийн 6.4.8-д заасны дагуу өр төлбөр үүсгэсэн шийдвэрийн мэдээллийг 100 хувь мэдээлсэн,
- Хуулийн 6.4.9-д заасны дагуу хууль тогтоомжид заасан бусад мэдээллийг 247 нь мэдээлж, Сэлэнгэ үржлийн цөм сүрэг, Төгөлдөр-Ерөө, Мандал хишиг хайрхан ОНӨААТҮГ-ууд мэдээлээгүй байна.

Б.3. Тус асуудал нь Сэлэнгэ аймагт хамааралгүй болно.

Б.4. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т хамаарах “Сэлэнгэ АЗЗА” ТӨХК нь 6 дугаар зүйлийн 6.8-д заасан мэдээлбэл зохих мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

Сэлэнгэ аймагт үйл ажиллагаа явуулж буй “Сэлэнгэ АЗЗА” ТӨХК -д хуулийн 6 дугаар зүйлийн 6.8.1, 6.8.3-д заасан мэдээллүүд хамааралгүй бөгөөд 6.8.2-т заасан 3 төрлийн мэдээлэл, 6.10-д заасан мэдээллүүдийг бүрэн байршуулсан байна.

Зураг 3

№	ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЛИЙН ТӨРӨЛ	2017 1 сар	2017 2 сар	2017 3 сар	2017 1-р унрал	2017 4 сар	2017 5 сар	2017 6 сар	2017 Хавас жил	2017 7 сар	2017 8 сар	2017 9 сар	2017 3-р унрал	2017 10 сар	2017 11 сар	2017 12 сар	2017 бүтэн жил
1	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө (Бүтэн жилээр)	—	—	—	—	—	—	—	—	—	—	—	—	—	—	—	—
2	Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл (Лухай бүр)	✓	✓	✓	—	✓	✓	✓	—	✓	✓	✓	—	✓	—	—	—
3	Концессийн мэдээлэл (Лухай бүр)	✓	✓	✓	—	✓	✓	✓	—	✓	✓	✓	—	✓	—	—	—
4	Худалдан авах ажиллагааны тайлан (Бүтэн жилээр)	—	—	—	—	—	—	—	—	—	—	—	—	—	—	—	—

“Сэлэнгэ АЗЗА” ТӨХК нь хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан 287.8 сая төгрөгийн шатахуун, 375.0 сая төгрөгийн автозамын битум худалдан авах нээлттэй тендерийг 2017 оны 2-р сард, 45.0 сая төгрөгийн асфальто дэвсгэгч, 35.0 сая төгрөгийн асфальтны хийн дугуйт индүү, 35.0 сая төгрөгийн уур үүсгэгч тогоо худалдан авах тендерийг 2.4-р саруудад харьцуулалтын аргаар тус тус зохион байгуулсан байна. /Дэлгэрэнгүйг Судалгаа 3-т харуулав./

Тендерийн үнэлгээний хорооны шийдвэрийг үндэслэн “Шатахуун, шатах тослох материал худалдах, худалдан авах” гэрээг Ник ХХК-тай, “Автозамын битум худалдан авах” гэрээг Саусгоби брэндс ХХК-тай, “Асфальто дэвсгэгч болон асфальтны хийн дугуйт индүү худалдан авах” гэрээг ЭМ ЭН БИ ЭС ХХК-тай, “Уур үүсгэгч тогоо худалдан авах” гэрээг Халаалтын тогоо ХХК-тай тус тус байгуулсан байна.

Шилэн дансны 4,6-р сарын мэдээнд нээлттэй болон харьцуулалтын аргаар зохион байгуулсан тендерийн ерөнхий мэдээллийг байршуулсан байна.

Б.4. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа ААНБ болон төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байгууллагууд Шилэн дансын тухай хуулийн 6-р зүйлийн 6.9-д заасан мэдээлбэл зохих 405 мэдээллээс 375 буюу 92.6 хувийг мэдээлсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн 6.9-д заасны дагуу 10,0 сая төгрөөс дээш үнийн дүн бүхий улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч болох 113 аж ахуйн нэгжид 4,408.7 сая төгрөгийн , төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль, тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч 22 хуулийн этгээдэд 816.7 сая төгрөгийн зэрэг нийт 5,225.4 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. /Дэлгэрэнгүйг Судалгаа 4,5-д харуулав/

Хуулийн 3.1.4-т хамаарах 113 аж ахуйн нэгжид олгосон 4,408.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний санхүүжилтийг аймаг, сумдын ОНЭД-ны “таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээлэл” цэсэнд мэдээлсэн байна.

Хуулийн 3.1.5-д хамаарах 22 хуулийн этгээдэд 816.7 сая төгрөгийн санхүүжилт олгосноос 10 хуулийн этгээдэд олгосон 161,7 сая төгрөгийн

санхүүжилтийн мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд мэдээлээгүй байна. Үүнийг байгууллага тус бүрээр харуулбал:

Хүснэгт 6

№	Байгууллагын нэр	Санхүүжилт олгосон байгууллагын нэр	Нийт санхүүжилтийн хэмжээ /сая.төг/	Олгосон санхүүжилт өссөн дүнгээр /сая.төг/	Санхүүжилтийн хувь
1	Аймгийн ахмадын хороо	Аймгийн Засаг дарга	31.7	23.8	75.0
2	Аймгийн албан журмын даатгуулагчдын холбоо	Аймгийн Засаг дарга	57.0	48.8	85.6
3	Ерөө сумын Лхачинбу мал эмнэлэг	ОНХС	12.8	3.2	25.0
4	Мандал сумын Тавансуварга	ОНХС	13.4	13.4	100
5	Орхон сумын ЭГДЭМ нөхөрлөл	ОНХС	12.3	12.3	100
6	Орхонтуул сумын Анар уул ББН	ХХААГ	10.5	10.5	100
7	Орхонтуул сумын Сүргийн ундраа ББН	ХХААГ	13.5	13.5	100
8	Сайхан сумын Цөм сүрэг ББН	ХХААГ	13.9	13.9	100
9	Хушаат сумын Эх жишиг ХХК	Хушаат сум ОНХС	12.0	12.0	100
10	Цагааннуур сумын Дэвжих дөл ХХК	Тус сумын санхүүгийн алба	10.3	10.3	100
Нийт дүн			187.4	161.7	86.3

Дээрх хүснэгтээс харахад аймгийн хэмжээнд гэрээний дагуу 10,0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн 22 хуулийн этгээдээс 10 нь холбогдох мэдээллийг байршуулаагүй байна.

Бүлэг В

Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлсэн эсэх

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд багийн ИНХ –ын зүгээс нэг ч хяналт хийгдээгүй байна.

В.1 Багийн иргэдийн Нийтийн хурал нь холбогдох байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 8.1-т “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал, төрийн аудитын байгууллага хэрэгжүүлнэ” гэж заасан байна.

Үүний дагуу 2017 оны 1-р сарын 31-ний өдрийн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 02 дугаар хуралдаанаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьсан Санхүүгийн хяналт, аудитын албаны мэдээллийг сонсож,

хэлэлцээд тус албаны дарга болон аймгийн Засаг дарга, орон нутгийн төсөвт байгууллага, ОНӨААТҮГ-ын дарга, захирал нарт үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг хангуулан, үнэлэлт, дүгнэлт өгсөн байна.

Сумдын хувьд Ерөө, Сант, Сайхан, Сүхбаатар, Хушаат, Хүдэр зэрэг 6 сумдын ИТХ нь ажлын хэсэг байгуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, дүгнэлт, зөвлөмж өгсөн байна.

Харин Баруунбүрэн, Зүүнбүрэн, Мандал, Түшиг, Цагааннуур, Шаамар сумын ИТХ нь хөндлөнгийн хяналт хийсэн боловч түүний мөрөөр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй байна.

Алтанбулаг, Баянгол, Жавхлант, Орхон, Орхонтуул зэрэг 5 сумын ИТХ-аас тайлант хугацаанд тухайн нутаг дэвсгэр дэх Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт хийгээгүй байна. Үүнийг графикаар харьцуулан харуулбал:

График 1



Өмнөх аудитаар 11 сумын ИТХ-аас хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийсэн дүн мэдээтэй байсан бол 2017 оны эхний 3 улирлын байдлаар уг үзүүлэлт 12 болж өссөн боловч хяналт шалгалтын мөрөөр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй, үнэлэлт, дүгнэлт өгөөгүй байгаа нь нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагууд уг хуулийн үйлчлэлд ач холбогдол өгч, төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангах талаар хангалтгүй ажиллаж байгааг харуулж байна.

Мөн багийн ИНХ-аас хөндлөнгийн хяналт хийхээр хуульчлагдсан боловч 17 сумын 56 багийн ИНХ-аас нэг нь ч хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Аудитын явцад сумдын ИНХ-ын зарим дарга нартай уулзаж, асуулга тодруулга авахад хөндлөнгийн хяналт тавих чиг үүргээ мэддэггүй, хэрхэн хяналт тавих талаар ойлголтгүй байлаа.

В.2 Аймгийн ТЕЗ-ийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2017 онд шилэн дансны үйл ажиллагаанд 2 удаа хяналт, шалгалт хийсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн 8-р зүйлийн 8.2 дахь “Төрийн болон, орон нутгийн өмчит хуулийн этгээд, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ” гэсэн заалтын дагуу аймгийн ТЕЗ-ийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2017 оны 2, 3-р улиралд тус бүр 1, нийт 2 удаа орон нутгийн төсөвт болон орон нутгийн өмчит

байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд дотоод хяналт хийж, дүгнэлт өгчээ.

Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2017 оны 01 сарын 01-нээс 10 сарын 01 хүртэлх хугацааг хамруулан хийсэн дотоод хяналтад орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа 261 байгууллагыг хамруулан, шилэн дансны мэдээлэл байршуулалт 79.2 хувьтай байна гэсэн дүгнэлт өгсөн байна.

Тус алба нь Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчлийг бууруулахын тулд 16 байгууллагад сургалт зохион байгуулж, зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байсан Ерөө сумын 6 байгууллагын удирдлагад шилэн дансны мэдээлэл байршуулахыг шаардсан албан шаардлага хүргүүлж, хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.

Цагааннуур, Зүүнбүрэн сумдын Санхүүгийн албанаас харьяа байгууллагуудынхаа Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, зөвлөмж өгчээ.

В.3 Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн өмчит хувьцаат компани зэрэг нийт 251 хуулийн этгээдээс 21 буюу 8 хувь нь дээд шатны байгууллагатай байгуулсан үр дүнгийн гэрээнд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг тусгаагүй байна.

Аудитын явцад төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн шууд захирагчдын үр дүнгийн гэрээ байгуулах, түүнийг дүгнэхдээ Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хэрхэн тусганыг авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

1. Төрийн өмчит 47 хуулийн этгээдээс ТЭДС-гийн Сэлэнгэ, Хөтөл салбар, аймгийн Нэгдсэн эмнэлэг, Сайхан сумын Нэгдсэн эмнэлэг, Стандарт хэмжил зүйн хэлтэс,
2. Орон нутгийн өмчит 173 хуулийн этгээдээс аймгийн ИТХ, Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтэс, Биеийн тамир спортын газар, аймгийн Нэгдсэн музей, ГХБХБГ, Орон нутгийн өмчийн алба, Сүхбаатар сумын ТҮГ, Алтанбулаг сумын 7 төсөвт байгууллага,
3. Орон нутгийн өмчит 12 аж ахуйн нэгжээс Сэлэнгэ үйлчилгээ, Сэлэнгэ-Зүүнхараа зэрэг 2 ОНӨААТҮГ-уудын дарга, захирал нар нь дээд шатны байгууллагатай үр дүнгийн гэрээ байгуулахдаа Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар тусгаагүй байна.
4. Мандал хишиг хайрхан, Төгөлдөр Ерөө зэрэг ОНӨААТҮГ-ын дарга нар сумдын Засаг дарга нартай гэрээ байгуулаагүй, үйл ажиллагаа огт явуулаагүй байна.

Дээд шатны төсвийн захирагчаас хяналт шалгалт хийгдсэн эсэхийг тодруулахад төрийн өмчит 8 байгууллага, орон нутгийн өмчит 24 байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийгдсэн бөгөөд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг давхар шалгасан байна. /Хавсралт 1-д дэлгэрэнгүй харуулав./

В.4 Шилэн дансны тухай хуулийн талаар иргэд, олон нийт тодорхой ойлголттой болсон боловч мэдээллийн цахим сангийн хандалтын талаар мэдээлэл авах боломжгүй байна.

Шилэн дансны цахим хуудсан дахь тухайн байгууллагын мэдээллийн цахим санд хандсан хандалтын тооны талаар мэдээлэл авах боломжгүй байгаа учир аудитын явцад 4 асуудлаар Сүхбаатар, Сайхан, Мандал, Ерөө, Цагааннуур,

Баянгол зэрэг томхон 6 сумын 201 иргэнээс цахим сангийн хандалтын талаар судалгаа авч, нэгтгэлээ.

Судалгааг асуулга тус бүрээр нэгтгэн авч үзвэл :

1. Судалгаанд оролцогчдоос төрийн байгууллагуудаас төсөв, санхүүгийн холбогдолтой ямар мэдээлэл авахыг сонирхож байгаа талаар асуулга авахад нийт иргэдийн 32 хувь нь тухайн байгууллагын батлагдсан төсөв, 37 хувь нь хөрөнгө оруулалт, тендер худалдан авалттай холбоотой мэдээлэл, 23 хувь нь бүтэц, орон тоонд гарсан өөрчлөлт, 8 хувь нь бусад мэдээллийг сонирхсон гэж хариулсан байна.
2. Та сонирхсон мэдээллээ хаанаас олж авч байна вэ? гэсэн асуултад хамгийн олон буюу 46 хувь нь тухайн байгууллагын шилэн дансны мэдээллийн самбараас, 28 хувь нь шилэн дансны нэгдсэн цахим сангаас, 16 хувь нь тухайн байгууллагын цахим хуудаснаас гэсэн бол 10 хувь нь бусад эх үүсвэрээс авдаг гэж хариулсан байна.

График 2, 3



3. Та сонирхсон мэдээллээ олж авч чадаж байна уу? гэсэн асуултад судалгаанд оролцсон иргэдийн 46 хувь нь тийм гэж хариулсан бол 43 хувь нь үгүй, 11 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна.
4. Шилэн дансны мэдээллийн ил тод байдалтай холбоотой сумын төр, төсвийн байгууллагууд шилэн дансны мэдээллийг ил тод, нээлттэй мэдээлж байна гэж үзэж байна уу? гэсэн асуултад нийт иргэдийн 60 хувь нь тийм, 22 хувь нь мэдэхгүй гэж хариулсан бол 18 хувь нь үгүй гэсэн хариулт өгсөн байна.

График 3,4



Судалгааны дүнг нэгтгэн авч үзвэл судалгаанд оролцогчдын 60 хувь нь мэдээллийг ил тод, нээлттэй мэдээлж байна, 46 хувь нь сонирхсон мэдээллээ авч чадаж байна, 46 хувь нь байгууллагын шилэн дансны мэдээллийн самбараас мэдээллийг авдаг, 37 хувь нь хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалттай холбоотой мэдээллийг илүү сонирхдог гэж хариулсан байгаагаас үндэслэн Шилэн дансны тухай хуулийн талаар иргэд, олон нийт тодорхой ойлголттой болсон байна гэж дүгнэж байна.

Шилэн дансны тухай хуулийн 9-р зүйлд заасан иргэний хяналтын талаар тодруулахаар аудитад хамрагдсан байгууллагын удирдлага болон аймаг, сумдын ЗДТГ-ын өргөдөл гомдол хариуцсан ажилтнуудаас асуулга авахад иргэдээс Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой санал хүсэлт ирж байгаагүй гэсэн хариултыг өгч байлаа.

Хуулийн 9.3 дахь заалтын хүрээнд аймгийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс тодруулга авахад 2017 оны 10-р сарын 25-ны өдрийн 113 дугаар албан бичгээр “Иргэн, хуулийн этгээдээс өргөдөл, гомдол хүлээн авч, шийдвэрлэж байгаагүй” гэсэн хариу ирүүлээ.

Бүлэг Г

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэх?

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлсэн бол зөвлөмжийг 79,2 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Г.1 Өмнөх аудитаар өгөгдсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлсэн байна.

2016 оны 11-р сард хийж гүйцэтгэсэн “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт” сэдэвт аудитаар жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилго бүхий “Аймаг хөгжүүлэх сан”- гийн 367.6 сая төгрөгийг зарцуулах шийдвэрийн мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд мэдээлэхийг шаардсан 1 албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлсэн байна.

Аудитын явцад албан шаардлагын хэрэгжилтийг шалгахад 2016 оны шийдвэрүүдийг нөхөн мэдээлсэн бөгөөд 2017 онд тус санд мэргэжилтний

цалингийн зардлаас өөр гүйлгээ хийгдээгүй тул албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлсэн гэж дүгнэж байна.

Г.2 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг дунджаар 79.2 хувьтай хэрэгжүүлсэн байна.

2016 оны 3-р улиралд хийсэн аудитаар аймгийн ИТХ-д 1, аймгийн ТЭЗ-5, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал нарт 1 зэрэг нийт 7 зөвлөмж хүргүүлснээс зөвлөмжийн хэрэгжилт дунджаар 79.2 хувьтай байна.

2016 оны 11-р сард хийгдсэн аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 7

д/д	Зөвлөмж өгөгдсөн албан тушаалтан	Зөвлөмжийн утга	Зөвлөмжийн хэрэгжилтийг хангасан байдал	Хэрэгжилтийн хувь
1.	Аймгийн ИТХ-ын дарга Г.Бямбаад	Шилэн дансны тухай хуулийн 8-р зүйлийн 8.1 дэх заалтын дагуу аймгийн ИТХ-ын зүгээс холбогдох байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт хийж, үнэлэлт дүгнэлт өгөх.	Аймгийн ИТХ нь 2017 оны 1-р сарын 31-ны өдрийн Тэргүүлэгчдийн хуралдаанаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тавьсан Санхүүгийн хяналт, аудитын албаны мэдээллийг сонсож, хэлэлцээд тус албаны дарга болон аймгийн Засаг дарга, орон нутгийн төсөвт байгууллага, ОНӨААТҮГ-ын дарга, захирал нарт тогтоолоор үүрэг даалгавар өгч ажилласан байна.	100.0
2.	Аймгийн ТЭЗ Ш.Оргилд	Шилэн дансны цахим санд цэс үүсгэсэн боловч мэдээллээ огт байршуулаагүй Сэлэнгэ үржлийн цөм сүрэг ОНӨААТҮГ-ын мэдээллийг шилэн дансанд байршуулах талаар холбогдох арга хэмжээ авах.	Сэлэнгэ үржлийн цөм сүрэг ОНӨААТҮГ-ын 2016 оны мэдээллийг оруулсан байна.	25.0
		Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа хуулийн этгээдүүдийн холбогдох мэдээллийг шилэн дансны цахим санд бүрэн байршуулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах, мэдээллээ бүрэн байршуулаагүй албан тушаалтнуудад хуулийн дагуу хариуцлага тооцох.	Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2017 онд Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд 2 удаа аудит хийж, зөвлөмж хүргүүлсэн бөгөөд хуулийг хангалтгүй хэрэгжүүлсэн Ерөө сумын 6 байгууллагад хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлж, биелэлтийг тооцсон байна.	100.0
		Шилэн дансны нэгдсэн цахим системд давхар үүсгэсэн, ашиглагдахгүй байгаа цэсүүдийг цэгцлэх.	Өмнөх оны аудитаар Хэрх, Түнхэл, Номгон, Бугант, Дулаанхаан тосгодууд, Алтанбулаг, Орхон сумдын хот тохижуулах газар, Түшиг сумын эмнэлэг давхар цэс нээлгэсэн байсныг Түшиг сумын	90.0

			эмнэлгээс бусад цэсийг тайлант онд бүрэн цэгцэлсэн байна.	
		Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль, тогтоомж, гэрээний үндсэн дээр хийж гүйцэтгэж буй хуулийн этгээдүүдийн мэдээллийг шилэн дансанд байршуулах талаар холбогдох арга хэмжээ авах.	Аймгийн ТЕЗ-ийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2016 оны 12-р сард шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 44 МЭҮН-д цэс нээж өгч, 2016 оны мэдээллийг ХХААГ-ын нягтлан бодогчтой хамтран оруулсан боловч 2017 онд МЭҮН-үүд мэдээллээ байршуулаагүй байна. Хувийн сургууль, цэцэрлэг, өрхийн эрүүл мэндийн төв зэрэг төрийн чиг үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгэж байгаа хуулийн этгээдүүд мэдээллийг улирал бүр оруулж хэвшсэн байна.	50.0
		Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийж буй дотоод хяналтын үр дүнг үнэлэх, өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийг тухай бүр тооцож байх.	Аймгийн ТЕЗ нь Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хийсэн дотоод хяналтын тайланг 2017 оны 1-р сард аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2-р хуралдаанаар авч хэлэлцүүлэн, тогтоолоор үүрэг даалгавар авч, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.	100.0
3.	Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал нарт	Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг хуулийн хугацаанд нь үнэн зөв мэдээлж, дутуу мэдээлсэн мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим системд 2016 оны 12-р сарын 20-ны өдрийн дотор нөхөн байршуулж, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.	Зөвлөмжийн хэрэгжилтийг ерөнхий дүнгээр нь авч үзвэл: 1. Төрийн өмчит 47 хуулийн этгээд 2016 онд 446 мэдээлэл байршуулах ёстойгоос 28 хувийг, 2017 онд 460 мэдээлэл байршуулах ёстойгоос 18 хувийг дутуу байршуулсан байна. 2. Орон нутгийн өмчит 191 хуулийн этгээд 2016 онд 2834 мэдээлэл байршуулах ёстойгоос 33 хувийг, 2017 онд 2943 мэдээлэл байршуулах ёстойгоос 21 хувийг дутуу байршуулсан байна. 3. Орон нутгийн өмчит 12 үйлвэрийн газар 2016 онд 160 мэдээлэл байршуулах ёстойгоос 48 хувийг, 2017 онд 169 мэдээлэл байршуулах ёстойгоос 41 хувийг дутуу байршуулсан байна. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал нарт өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 90.0 хувьтай байна.	90.0
Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь /дунджаар/				79.2

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал нарт өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс шилэн дансны цахим санд мэдээлбэл зохих мэдээллийн 50.0- 66.7 хувийг мэдээлээгүй байсан *Сүхбаатар сумын 3-р сургууль*,

Хушаат сумын цэцэрлэг, Хүдэр сумын эмнэлэг, Сэлэнгэ Зүүнхараа ОНӨААТҮГ зэрэг байгууллага, аж ахуйн нэгжийн мэдээллүүдийг аудитын явцад нөхөн мэдээлүүлэв.

Харин Сэлэнгэ үржлийн цөм сүрэг ОНӨААТҮГ нь 2017 оны мэдээллийг огт мэдээлээгүй бол Орхонтуул сумын 1,2 дугаар бүрэн дунд сургуулиуд мэдээлбэл зохих мэдээллийн 50.0-52.9 хувийг цахим санд байршуулаагүй байна.

АУДИТААР ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧИЛ.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитаар шилэн дансны цахим санд мэдээлбэл зохих **8,892,4 сая** төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй зөрчил илэрлээ. Үүнд:

1. **5,0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаягийн мэдээллийг байршуулаагүй нийт 3,864.3 сая төгрөгийн. Үүнд:**
 - Улсын төсвийн 17 байгууллага 54 худалдан авалтын 872.8 сая төгрөгийн,
 - 13 сумын орон нутгийн төсвийн болон ТЗШ-ийн 71 байгууллага худалдан авалтын 2,948.4 сая төгрөгийн,
 - 1 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж 11 удаагийн 43.1 сая төгрөгийн.
2. **Цалингийн зардлаас бусад 5,0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээг мэдээлээгүй 2,865.4 сая төгрөгийн. Үүнд:**
 - Улсын төсвийн 7 байгууллага 23 удаагийн 284.0 сая төгрөгийн,
 - 15 сумын, орон нутгийн төсвийн болон ТЗШ-ийн 57 байгууллага 239 удаагийн 2,527.8 сая төгрөгийн,
 - 2 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж 7 удаагийн 53.6 сая төгрөгийн зарлагын гүйлгээ.
3. **5,0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын гүйлгээг мэдээлээгүй 1,009.2 сая төгрөгийн. Үүнд:**
 - Улсын төсвийн 3 байгууллага 3 удаагийн 26.8 сая төгрөгийн,
 - Орон нутгийн төсвийн болон ТЗШ-ийн 12 байгууллага 57 удаагийн 895.7 сая төгрөгийн,
 - 2 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж 3 удаагийн 86.7 сая төгрөгийн орлогын гүйлгээ.
4. **Төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн талаар мэдээлээгүй 991.8 сая төгрөгийн. Үүнд:**
 - Улсын төсвийн 11 байгууллага 33 удаагийн 79.9 сая төгрөгийн,
 - Орон нутгийн төсвийн болон ТЗШ-ийн 64 байгууллага 361 удаагийн 821.5 сая төгрөгийн,
 - 5 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж 73 удаагийн 90.4 сая төгрөгийн орлогын гүйлгээ.
5. Сэлэнгэ аймагт төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль, тогтоомж, гэрээний үндсэн дээр хийж гүйцэтгэгч 10 байгууллага 161.7 сая төгрөгийн санхүүжилтийн мэдээллийг мэдээлээгүй,
6. Тухайн жилийн төсвийг 01-р сарын 10-ны өдрийн дотор мэдээлэхээс улсын төсвийн 4, орон нутгийн болон ТЗШ-ийн 21 байгууллага, 4 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж зэрэг нийт 29 хуулийн этгээд мэдээлээгүй,

8. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг жил бүрийн 01-р сарын 10-ны өдрийн дотор мэдээлэхээс улсын төсвийн 37, орон нутгийн болон ТЗШ-ийн 149 байгууллага, 11 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж зэрэг нийт 197 хуулийн этгээд мэдээлээгүй,
9. Дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор мэдээлэхээс улсын төсвийн 9, орон нутгийн болон ТЗШ-ийн 49 байгууллага, 11 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж зэрэг нийт 69 хуулийн этгээд мэдээлээгүй,
10. 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор мэдээлэхээс улсын төсвийн 5, орон нутгийн болон ТЗШ-ийн 28 байгууллага, 4 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж зэрэг нийт 37 хуулийн этгээд мэдээлээгүй,
11. 2017 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор мэдээлэхээс улсын төсвийн 3, орон нутгийн болон ТЗШ-ийн 30 байгууллага, 7 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж зэрэг нийт 40 хуулийн этгээд мэдээлээгүй,
12. Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор мэдээлэхээс улсын төсвийн 4, орон нутгийн болон ТЗШ-ийн 42 байгууллага, 7 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж зэрэг нийт 53 хуулийн этгээд мэдээлээгүй,
13. Аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор мэдээлэхээс улсын төсвийн 10, орон нутгийн болон ТЗШ-ийн 63 байгууллага, 9 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж зэрэг нийт 82 хуулийн этгээд мэдээлээгүй,
14. Төсвийн хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, тайлбарыг улирал бүр мэдээлэхээс улсын төсвийн 3, орон нутгийн болон ТЗШ-ийн 23 байгууллага, 5 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж зэрэг нийт 31 хуулийн этгээд мэдээлээгүй,
15. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлтийг улсын төсвийн 3, орон нутгийн болон ТЗШ-ийн 11 байгууллага, 6 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж зэрэг нийт 20 хуулийн этгээд мэдээлээгүй,
16. Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг орон нутгийн болон ТЗШ-ийн 2 байгууллага, 7 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж зэрэг нийт 9 хуулийн этгээд мэдээлээгүй,
17. Худалдан авалтын аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүнгийн талаарх мэдээллийг улсын төсвийн 7, орон нутгийн болон ТЗШ-ийн 2 байгууллага, 7 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж зэрэг нийт 16 хуулийн этгээд мэдээлээгүй,
18. Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг улсын төсвийн 4, орон нутгийн болон ТЗШ-ийн 11 байгууллага, 4 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж зэрэг нийт 19 хуулийн этгээд мэдээлээгүй зэрэг зөрчил илэрлээ.
19. Үйл ажиллагаа явуулж байгаа "Сэлэнгэ үржлийн цөм сүрэг" ОНӨААТҮГ нь шилэн дансны цахим хуусанд 2017 оны эхний 3 улирлын байдлаар мэдээлбэл зохих мэдээллийг огт оруулаагүй байна.

Дээрх зөрчлөөс гадна өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс шилэн дансны цахим хуудсаар мэдээлбэл зохих мэдээллийг огт мэдээлээгүй Сэлэнгэ үржлийн цөм сүрэг ОНӨААТҮГ болон 50.0-52.9 хувийг

мэдээлээгүй Орхонтуул сумын 1, 2 дугаар бүрэн дунд сургуулийн холбогдох албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг хүргүүлэв.

АУДИТЫН ДҮГНЭЛТ.

Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд нь шилэн дансны цахим санд мэдээлбэл зохих 102,772.0 сая төгрөгийн мэдээллээс 93,879.6 сая төгрөгийн буюу 91.3 хувийг мэдээлсэн байна.

1. Шилэн дансны тухай хуулийн үйлчлэлд хамаарах 386 хуулийн этгээд шилэн дансны цахим санд өөрийн нэрээр цэс үүсгэсэн байна.
2. Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд нь шилэн дансны цахим хуудсаар мэдээлбэл зохих 12905 удаагийн мэдээллээс 10675 буюу 82.7 хувийг, самбараар мэдээлбэл зохих 12905 удаагийн мэдээллээс 9057 буюу 70.1 хувийг мэдээлсэн байна.
3. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газрууд Шилэн дансны тухай хуулийн 6-р зүйлийн 6.1-д заасан мэдээлбэл зохих 5171 мэдээллээс 4491 буюу 86.8 хувийг мэдээлсэн байна.
4. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газрууд 7 хоногийн дотор мэдээлбэл зохих 7734 мэдээллээс 6184 буюу 80.0 хувийг мэдээлсэн байна.
5. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т хамаарах “Сэлэнгэ АЗЗА” ТӨХК нь 6 дугаар зүйлийн 6.8-д заасан мэдээлбэл зохих 4 мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.
6. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа ААНБ болон төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байгууллагууд Шилэн дансын тухай хуулийн 6-р зүйлийн 6.9-д заасан мэдээлбэл зохих 405 мэдээллээс 375 буюу 92.6 хувийг мэдээлсэн байна.
7. Багийн иргэдийн Нийтийн хурал нь холбогдох байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.
8. Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2017 онд шилэн дансны үйл ажиллагаанд 2 удаа хяналт, шалгалт хийсэн байна.
9. Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн өмчит хувьцаат компани зэрэг нийт 251 хуулийн этгээдээс 21 буюу 8 хувь нь дээд шатны байгууллагатай байгуулсан үр дүнгийн гэрээнд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг тусгаагүй байна.
10. Шилэн дансны тухай хуулийн талаар иргэд, олон нийт тодорхой ойлголттой болсон боловч мэдээллийн цахим сангийн хандалтын талаар мэдээлэл авах боломжгүй байна.
11. Өмнөх аудитаар өгөгдсөн албан шаардлагыг бүрэн биелүүлсэн байна.
12. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг дунджаар 79.2 хувьтай хэрэгжүүлсэн байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна.

Аймгийн Засаг дарга Ш.Оргилд:

1. Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа хуулийн этгээдүүдийн холбогдох мэдээллийг шилэн дансны цахим санд бүрэн байршуулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах.
2. Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль, тогтоомж, гэрээний үндсэн дээр хийж гүйцэтгэж буй аймгийн Ахмадын холбоо болон албан журмын даатгуулагчдын холбоо, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн мэдээллийг шилэн дансанд байршуулах .

Сумдын ИТХ-ын дарга нарт:

1. Багийн иргэдийн Нийтийн хурлын дарга нарын ажлыг дүгнэхдээ Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьсан эсэхийг гол үзүүлэлт болгож байх.
2. Шилэн дансны хэрэгжилтэд хуульд заасны дагуу хөндлөнгийн хяналт хийж, үнэлэлт, дүгнэлт өгч хэвших.

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал нарт:

1. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг хуулийн хугацаанд нь үнэн зөв, бүрэн мэдээлэх.
2. 2017 оны 3 дугаар улирлын байдлаарх дутуу мэдээлсэн мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим санд 2017 оны 12-р сарын 20-ны өдрийн дотор нөхөн байршуулах.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ч.ЭНХТУЯА
Б.БАТМӨНХ
С.БААСАНСҮРЭН
Ц.ОТГОНБАЯР



СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

213200 Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг
Утас/Факс: 7036-3834

2017.11.20 № 7/183
танай 2017.11.16 -ны № 219 -т

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

“Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-д хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Тайлантай холбоотой санал хүсэлт байхгүй ба зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах болно.

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэхэд дараах хүндрэлүүд үүсдэг тул дээд шатны байгууллагуудад уламжилж өгнө үү. Үүнд:

-Шилэн дансны цахим хуудас сарын 1-8-ны өдрүүдэд ачаалал ихэсч ажилладаггүй, сумдын интернет муу учраас алдаа заадаг, мөн програмаас шууд татдаггүй тул нягтлан бодогчдын ажлын ачааллыг нэмдэг.

-Оруулсан мэдээлэлд засвар оруулахад хугацаа хоцорсон тэмдэглэгээтэй болдог.

-Оруулсан мэдээлэл хадгалагддаггүй, нийлбэр нь бодогддоггүй, зарим мэдээллүүд баталгаажуулахад алдаа зааж ордоггүй гэх мэт хүндрэлүүд үүсдэг.

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА М.НАРАНТУЯА

/ZDTG/ Jijig toot

